

ИРГЭН Г.БЯМБАДАГВА
Захиалагч



“ЦАГААН УУЛЫН ОРГИЛ” ХХК
Гүйцэтгэгч

2024

БАЙГАЛЬ ОРЧНЫ
МЕНЕЖМЕНТИЙН
ТӨЛӨВЛӨГӨӨ



АРХАНГАЙ АЙМАГ, ТАРИАТ СУМ, ХАР ЧУЛУУТЫН АМ

УЛААНБААТАР ХОТ
2024 он

2024 ОНЫ БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Оршил

1. Төслийн товч танилцуулга
2. Байгаль орчны төлөв байдлын товч тодорхойлолт
3. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
4. Байгаль орчны менежментийн тухайн жилийн төлөвлөгөөний гол зорилт
5. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
6. Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө
7. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө
8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө
9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр
10. Тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө
11. Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

ОРШИЛ

Иргэн Г.Бямбадагвын Архангай аймаг, Тариат сум, Хар чулуутын ам, Хорго-Тэрхийн цагаан нуурын байгалийн цогцолборт газарт хэрэгжүүлж буй “Нуурын өглөө” жуулчны бааз төслийн 2024 оны Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ)-г Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 10-р сарын 29-ны өдрийн А-618 тоот тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын дагуу байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан Уулын Оргил” ХХК боловсруулав.

Байгаль орчны менежментийн 2024 оны төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (6), Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө (2), осол, эрсдэлийн төлөвлөгөө (3), хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (3), орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (4), удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө (10), БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах (4), нийт 29 ажил, арга хэмжээ багтсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд 48.5сая.төг зарцуулахаар төлөвлөв.


Төслийн онцлог, байршлаас шалтгаалан нөхөн сэргээлтийн төлөвлөгөө, дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ, химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө, нүүлгэн шилжүүлэх нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө болон түүх соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө хийгдэхгүй болно.

Төсөл хэрэгжүүлэгч нь жил бүрийн XI сарын 1-ний дотор тухайн жилийн БОМТ-ийн хэрэгжилтийн тайланг төлөвлөгөөнд тусгасан арга хэмжээний дагуу гаргаж, дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг XII сарын 31-ний дотор БОАЖЯ-д хүргүүлнэ.

НЭГ. ТӨСЛИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

1.1. Төслийн товч тодорхойлолт

Төслийн нэр:	“Нуурын өглөө” жуулчны бааз
Төсөл хэрэгжүүлэгч:	Иргэн Г.Бямбадагва,
Төслийн зорилго:	“Хорго-Тэрхийн Цагаан нуур”-ын байгалийн цогцолборт газарт нутгийн иргэд аялагч, амрагчдад түшиглэсэн “Эко” аялал жуулчлалын төрлийг хөгжүүлэх, ая тухтай аялах, амрах нөхцөлийг бүрдүүлэх, орон нутагт ажлын байр нэмэгдүүлэх, амралт аялал жуулчлалын газар байгуулах
Газар ашиглах гэрчилгээний дугаар:	0201672
Регистрийн дугаар:	A353041111
Холбогдох утас:	99050636
Төслийн байршил:	Архангай аймаг, Тариат сум, Хар чулуутын ам, Хорго-Тэрхийн цагаан нуурын урд эрэгт, Архангай-Завхан чиглэлийн автозам дагуу байрлалтай.
Талбайн хэмжээ:	1.5 га
Хүчин чадал:	Нэг удаад 50-60 амрагч, жуулчдыг хүлээн авна.
Ажиллах хүч:	Захиргаа, маркетинг, санхүү, үйлчилгээ гэсэн хэсгүүдэд 10-10 хүн ажиллана.
Ус хангамж:	Өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг.
Цахилгаан хангамж:	Төвийн шугам сүлжээнд холбогдсон.
Солбицол:	99° 48' 28.051" E 48° 08' 24.207" N 99° 48' 29.548" E 48° 08' 27.461" N 99° 48' 31.031" E 48° 08' 27.154" N 99° 48' 37.274" E 48° 08' 24.829" N 99° 48' 36.234" E 48° 08' 22.534" N



Зураг 1.1. Төслийн байршил

Төслийн хүчин чадал: Тус компаний эко аялал жуулчлалын бааз нь жилийн 4 улирлын турш ажиллах бөгөөд бүрэн хүчин чадлаараа ажиллахад 10 ажилтантай, нэг дор 50-60 хүн хүлээн авах хүчин чадалтай.

Жуулчны бааз нь гал тогоо, 6 ортой таван ханатай гэр буудал-7 ширхэг, 2 ортой жижиг гэр-5 ширхэг, нийтийн ариун цэврийн байгууламжийн байшин болон тоглоомын талбай, авто зогсоол зэргээс бүрдэнэ.



Зураг 1.2. Жуулчны бааз



Зураг 1.3. Жуулчны баазын 4 талаас харагдах байдал

1.2. Усны хэрэглээ

Баазын усны хэрэглээг өөрийн эзэмшлийн гүний худгаас хангадаг. Баазын усны хэрэглээг Архангай аймгийн БОАЖ-ын газрын 2022 оны 6 дугаар сарын 6-ны өдрийн 7 дугаартай “Ус ашиглуулах дүгнэлт”-ийг үндэслэн дараах байдлаар тооцоход жилд 721.9.м3 ус ашиглах тооцоотой байна.

Ажилчдын унд ахуйн усны хэрэглээ: Жуулчны баазад 10 ажилтан ажиллах бөгөөд 1 ажилтанд шаардагдах усны хэмжээ 150 л/хоног.

Хүснэгт 1.1. Ажилчдын унд ахуйн усны хэрэгцээний тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л/хоног)	Ажиллах хүчин (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.м3)
1	1 хоног	150	10	1.5
2	1 жил (90 хон)			135.0
3	5 жил			675.0

Жуулчдын усны хэрэглээ: Жуулчны бааз нэг ээлжинд 50-60 хүн хүлээн авах хүчин чадалтай бөгөөд өдөрт дунджаар 20 хүн амрахаар тооцоолов. (Дундын ариун цэврийн өрөөтэй жуулчны баазын усны норм 180л/хоног)

Хүснэгт 1.2. Жуулчдын усны хэрэгцээний тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л/хоног)	Хүчин чадал (хүн)	Шаардагдах усны хэмжээ (мян.м³)
1	1 хоног	180	0	3.6
2	1 жил (90 хон)			324.0
3	5 жил			1620.0

Мод усалгаа: “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд 2023 онд суулгасан суулгацын усалгааг газрын гадаргын хэлбэржилтээс шалтгаалан жилд 8 удаа услахаар тооцоолов. (БОНХАЖСайдын 2015 оны А/301 дугаар тушаалын 13 дугаар хавсралт “Зүлэгжүүлэлт, зам талбайн усалгааны норм”, 1 ширхэг суулгацын усалгааны норм 40л)

Хүснэгт 1.3. Мод усалгааны тооцоо

№	Хугацаа	Усны норм, (л/хоног)	Суулгац (ширхэг)	Шаардагдах усны хэмжээ (мян.м³)
1	1 хоног	40	41	1.6
2	1 жил (90 хон)			13.1
3	5 жил			65.5

Нийт $135.0+135.0+114.8+324.0+13.1=721.9\text{м}^3/\text{жил}$

Байгалийн нөөц ашигласны төлбөр: Баазын үйл ажиллагаанд жилд 721.9м^3 ус шаардагдах тооцоотой байна. Үүнд үндэслэн усны нөөц ашигласны төлбөрийн хэмжээг дараах байдлаар тооцов. Үүнд:

$$1\text{м}^3 \text{ ус ашигласны төлбөр. } 1510 \cdot 0.15 \cdot 0.4 \cdot 2 = 181.2 \text{ төг/м}^3$$

- Чулуут голын сав газарт газрын доорх ус ашигласан нөхцөлд экологи эдийн засгийн суурь үнэлгээ - 1510 төг, - Засгийн газрын 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт, “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ” 10. Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэдэг ИААНБ-ын ашигласан усны шоо метр тутамд газрын доорх усны төлбөрийн хувь хэмжээ - 15%

- Ашиг олох зориулалтаар ахуйн үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэхэд газрын доорх ус ашиглалт тооцох итгэлцүүр - 0.4*2 (Улсын тусгай хамгаалалттай газар нутагт ус ашигласан тохиолдолд экологийн итгэлцүүрийг 2 дахин нэмэгдүүлж тооцно)

Хүснэгт 1.4. Усны нөөц ашигласны төлбөрийн тооцоо

№	Усны хэмжээ, мян.м ³	1 хоног	1 жил	5 жил	Усны төлбөр, төг/м ³	Усны нөөц ашигласны төлбөр, мян. төг/жил
1	Ажилчдын унд ахуй	1.5	135.0	675.0	181.2	-
2	Амрагчдын ус хэрэглээ	3.6	324.0	1620.0		58.7
3	Зоогийн газрын ус	1.5	135.0	675.0		24.5
4	Угаалга цэвэрлэгээний ус	1.3	114.8	574.0		20.8
5	Мод усалгаа	1.6	13.1	65.5		2.4
Нийт		9.5	721.9	3609.5		130.8

Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 20.1.1 дүгээр заалтын дагуу хүн амын унд ахуйн хэрэгцээнд ашиглах усыг төлбөрөөс чөлөөлнө.

ЗГ-ын 2011 оны 302 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Усны экологи-эдийн засгийн суурь үнэлгээ”, 2013 оны 326 дугаар тогтоолын 1 дүгээр хавсралт “Усны нөөц ашигласны төлбөрийн хувь, хэмжээ”, 327 дугаар тогтоолын хавсралт “Ашиглалтын зориулалтыг тооцох итгэлцүүр”-ыг тус тус үндэслэн усны төлбөрийн хэмжээг тооцоход жилд 227.5 мян.төг төлөх тооцоотой байна. “Усны тухай хууль”-ийн 30.1.4-д заасны дагуу ус татах шугам хоолойд баталгаажуулсан тоолуур суурилуулж, тоолуурын заалтаар усны нөөц ашигласны төлбөрийг тооцож, “Төсвийн тухай хууль”-ийн 23.6.5-д заасны дагуу аймгийн төсөвт төвлөрүүлэх хэрэгтэй.


1.3. Хог хаягдал


Жуулчны баазын оргил ачааллын үед хоногт 0.08-0.11тн хаягдал гарна гэж тооцвол жилд дунджаар 23 - 32тн хатуу хог хаягдал үүсэхээр байна. Үүсч буй хог хаягдлын хэмжээг төрөл, бүтцээр нь тоймлон дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 1.5. Жилд үүсэх хог хаягдлын хэмжээ

Эх үүсвэр		Ангилал	Үүсэх хэмжээ жилд /м ³ /
Хатуу хог хаягдал, тн	Ажиллагсад	Дахивар	0.54-0.81
		Энгийн	1.26-1.89
	Жуулчид	Дахивар	35.07-54.11
		Энгийн	28.45-29.63
	Зоогийн газар	Дахивар	20.09-23.12
		Энгийн	19.71-26.28
Шингэн хаягдал, м ³	Унд ахуйн хэрэглээ	Дахин ашиглах боломжтой	3000-3170
	Үйлчилгээ		1344-1380
	Угаалга		1260-1300

Хүснэгт 1.6. Дахин ашиглах боломжтой хог хаягдлын хэмжээ, /м³/

Хог хаягдлын төрөл		Хэмжээ	Дахин ашиглах арга хэмжээ
 Хатуу хаягдал, тн	Шил	11.1-15.7	Дахин боловсруулах боломжтой гялгар уут, хуванцар, шил лаазыг сумын төв дахь хоёрдогч түүхий эд боловсруулдаг хувь хүн, аж ахуйн нэгжид тушаах, бусад энгийн
	Лааз	4.91-6.93	
	Хуванцар	6.70-9.45	
	Гялгар уут	0.44-0.63	
	Шуудай	2.23-3.15	
	Цаас	1.34-1.89	
	Хоолны үлдэгдэл, ногооны хальс	17.8-25.2	Компост бордоо хийж ашиглах



Зураг 1.4. Нийт хог хаягдал болон дахин ашиглах боломжтой хог хаягдлыг хэмжээ, ангиллаар

ХОЁР. БАЙГАЛЬ ОРЧНЫ ТӨЛӨВ БАЙДЛЫН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Физик газарзүйн нөхцөл, байгалийн бүс, бүслүүр: Төслийн талбай орчим нь Монгол орны физик газарзүйн мужлалаар Хангай Хэнтийн уулархаг их мужийн Хангайн гол нуруудын хэсэгт, ландшафтын хэлбэрээр Тариатын умардын хуурай хээр, нуга, ар хажуугийн ойн бүсэд тус тус хамаарна. Төслийн талбай нь 2057-2059м-ийн өндөршилд газар хөдлөлийн 8 баллын мужид оршиж байна.

Цаг уурын нөхцөл: Уур амьсгалын хувьд чийглэг нэн сэрүүн мужийн нэн хүйтэн дэд мужид орших бөгөөд Тэрхийн Цагаан нуурын эрэг орчим зун нь сэрүүн-чийглэг, өвөл нь хүйтэн-чийглэг, I сарын дундаж температур $-21.8(-23.9)^{\circ}\text{C}$ хүйтэн, VII сард $+10(+14)^{\circ}\text{C}$ дулаан, хөрсний гадаргын жилийн дундаж температур -3.2°C хүйтэн, цасан бүрхүүлтэй үед агаарынхаас $1-2^{\circ}\text{C}$ ээр хүйтэн, дулаан улиралд $3-4^{\circ}\text{C}$ дулаан, агаарын даралт $791\text{гПа}/593\text{м.у.б}/$, жилийн дундаж харьцангуй чийгшил $63-67$ хувь, Тэрхийн цагаан нуур орчмоор олон жилийн дундаж хур тунадас $300-400\text{мм}$, салхины зонхилох чиглэлүүдийн дундаж хурд $3.0-5.4\text{м/с}$, үнэмлэхүй их хурд хавраас бусад сард $14-18\text{м/с}$, хавар $20-25\text{м/с}$ хүрдэг, нарны нийлбэр цацраг 4540мДж/м^2 орчим, жилд $15-20$ өдөр аянга цахилгаантай, хэвтээ гадаргад цасны ачаалал $50-70\text{кг/м}^2$ байдаг байна.

Геологийн тогтоц: Хорго, Тэрхийн цагаан нуур орчмын уулс нь геологийн гарал үүслийн хувьд девоны үеийн боржин чулуу, дөрөвдөгч галбын галт уулын гаралтай чулуулагтай. Геоморфологийн хувьд Тариат сум нь Хангайн нурууны гол нуруу түүний салбар хэсэг тойрог уулсын мужид хамаарах бөгөөд Тэрхийн цагаан нуурын орчим өндөр уулс, хуримтлагдсан хурдаст тал зонхилсон хэв шинжтэй ба төслийн талбай нь хөндий, хотгор бүхий талд байрладаг. Тектоникийн хувьд төслийн талбайн орчимд Дунд эрт төрмөлийн галт уулын тогтоц тархсан байна.

Ус: Тэрхийн Цагаан нуурт цутгах гол горхи, нуураас эх авсан Суман гол нь Орхон-Чулуутын голын сав газарт хамаардаг. Тэрхийн цагаан нуур нь цэнгэг, нуурын усны дундаж эрдэсжилт 171мг/л , устөрөгч ионы (рН) агууламж усны түвшнээс хамааран сул хүчиллэгээс сул шүлтлэг шинжтэй, химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, натрийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэгдүү буюу дунд зэргийн эрдэсжилттэй, зөөлөн ус бөгөөд шинжилсэн үзүүлэлтүүд нь “Ундны усны чанарын стандарт. MNS 900:2005”-н шаардлага хангаж байна. Газрын доорх усны хувьд усны сэргээгдэх нөөц боломж сайн, нутгийн ихэнх хэсэгт гүний усны сэргээгдэх нөөц жилд $10-20\text{мм/км}^2$ байдаг байна.

Хөрс: Тариат сумын ус, намгархаг газарт ерөнхийдөө их ялзмагтай хар хүрэн, хүлэрт хөрстэй, дов сондуултай газар элбэгтэй ба нутгийн ихэнх хэсэгт цэвдгийн шаварлаг хөрс тохиолддог, төслийн талбай орчимд ердийн харшороон ба нугат цэвдэгт хүрэн хөрс зонхилдог.

Ургамал: Хорго-Тэрхийн Цагаан нуур хавийн нутаг нь ургамлын мужлалаар Хангайн дүүргийн умард хангайн мужид багтах бөгөөд төслийн талбай орчимд хялгана, чаргай, боролзгоно оролцсон ботууль алаг өвст бэлчээр тархсан байна. Мөн Тариат суманд сийрэг хар мод-шинэсэн ой зонхилох бөгөөд Далайн түвшнээс дээш $2.100-2.600$ метр өндөр уулс бүхий газрууд шинэсэн ойгоор хучигдсан байдаг. Түүний заагуур зүйлүүд нь сибир Шинс, Жамъянмядаг, Шимтэглэй, сибирь Биелэг, Турчаниновын Хонхон цэцэг, Сөд, Банбуй, Сибирь Чөдөргөнө өвс болно.

2.1. Орчны хяналт шинжилгээ

а. Усны чанар, шинжилгээ: Усны чанар, шинжилгээ: Хэрэглээний худгийн усны 2021 оны 07 дугаар сарын 20-ны өдөр Архангай аймгийн мэргэжлийн хяналтын газрын нэгдсэн лабораторийн хийсэн химийн шинжилгээ болон 2021 оны 09 дүгээр сарын 21-ны өдөр ШУА, Газарзүй-Геоэкологийн хүрээлэнгийн усны шинжилгээний лабораторийн хийсэн ерөнхий шинжилгээний дүнгүүдийг ашиглав.

Хүснэгт 2.1. Дээж авсан тэмдэглэл

Дээжний нэр:	Худгийн ус
Дээж авсан аргачлал:	физик-химийн шинжилгээний графикийн дагуу
Дээжний тоо хэмжээ:	2.5 л
Дээж шинжилсэн огноо:	2021.09.21
Сорьц авсан байршил	48° 09' 36.01" N 99° 53' 16.20" E
Шинжилсэн үзүүлэлт	Ерөнхий

Хүснэгт 2.2. Усны химийн шинж чанар

Шинжилгээний аргын стандарт	Шинжилсэн үзүүлэлт	Шаардлага, нэгж	Шинжилгээний дүн
MNS ISO 6222:1998	ББЕТ	100	1 мл-т 5
MNS ISO 19250:2017	Salmonella app	илрэхгүй	25 мл-т илрээгүй
MNS ISO 9308-1:1998	Халуунд тэсвэртэй гэдэсний бүлгийн нян /ялтас шүүлтүүр/	илрэхгүй	100 мл-т илрээгүй
MNS 1097:1970	Кальци ион	100 мг/л	22.55
	Магни ион	30 мг/л	4.86
MNS 4430:2005	Нийт төмөр	0.3 мг/л	0.17
MNS ISO 7890:3:2001	Нитрат	50 мг/л	4.64
MNS 6779:2019	Нитрит	1 мг/л	0.02
MNS 6271:2011	Сульфат	500 мг/л	9.85
MNS ISO 7393-3:2008	Үлдэгдэл хлор	0.3 мг/л	0.0
MNS 6272:2011	Фтор	0.7-1.5 мг/л	0.05
MNS 6778:2019	Хатуулаг	7 мг/л	1.53
MNS 4424:2005	Хлорид	350 мг/л	8.86
MNS 4423:1997	Хуурай үлдэгдэл	1000 мг/л	0.54

Хүснэгт 2.3. Усны химийн шинж чанар


Катион	1дм ³ -д байгаа			Анион	1дм ³ -д байгаа		
	мг/л	мг-экв/л	мг-экв/%		мг/л	мг-экв/л	мг-экв/%
Na ⁺ +K ⁺	14.6	0.64	29.79	CO ₃ ⁻	0.0	0.00	0.00
Ca ⁺⁺	20.0	1.00	46.81	HCO ₃ ⁻	109.8	1.80	84.25
Mg ⁺⁺	6.1	0.50	23.40	Cl ⁻	7.1	0.20	9.36
NH ₄ ⁺	0.0	0.00	0.00	SO ₄ ⁻	5.0	0.10	4.88
Fe ⁺⁺	0.0	0.00	0.00	NO ₃ ⁻	2.0	0.03	1.51
Fe ⁺⁺⁺	0.0	0.00	0.00	NO ₂ ⁻	0.0	0.00	0.00
Äĳí	40.8	2.14	100.00	Дүн	123.9	2.14	100.00

Хүснэгт 2.4. Усны физик шинж чанар

Дээж авсан газар	HCO ₃ ⁻ -ийн хагасыг хассан анион, катионуудын нийлбэр, мг/л	Анион, катионуудын нийлбэр, мг/л	Физик үзүүлэлтүүд								
			Ерөнхий хатуулаг, мг-экв/л	pH	Цахилгаан дамжуулах чанар, ds/m	TDS, ppm	Хуурай үлдэгдэл, ppm	Өнгө, град	Үнэр, балл	Амт, балл	Тунгалаг, см
Гүний худаг	109.8	164.7	1.50	7.42	174	97	159	0	0	0	30

Шинжилгээний дүнгээр худгийн ус нь химийн бүрэлдэхүүнээрээ гидрокарбонатын ангийн, кальцийн бүлгийн, 1-р төрлийн, чанарын хувьд цэнгэг зөөлөн ус байна. “Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 900:2018 стандартын шаардлага хангаж байна.

б. Хөрсний ерөнхий шинжилгээ: Судалгааны ажлын хүрээнд төслийн талбайгаас хөрсний химийн үндсэн шинж чанарыг тодорхойлох зорилгоор дээж авч “Инженер геодези” ХХК-ий хөрсний лабораторид шинжлүүлэв.



Дээж авсан цэгийн координат
Баазын хашаан дотроос
Солбилцол
48° 08' 24.879" N 99° 48' 33.711" E

Зураг 2.1. Хөрсний зүсэлт

Хүснэгт 2.5. Хөрсний химийн үндсэн шинж

Дээж авсан үе давхарга	pH	Давс, %	Ялзмаг, %	EC _{2,5} , dS/m	CO ₂	Солилцох суурь, мг/100гр			Шим тэжээлийн мг/100гр		
						Ca+Mg	Ca	Mg	NO ₃	P ₂ O ₅	K ₂ O
А үе	7.4	0.02	0.31	0.045	0.00	12.6	8.9	3.7	0.15	0.8	9

Хүснэгт 2.6. Хөрсний механик бүрэлдэхүүн

Дээж авсан гүн, см	Механик ширхэгүүд (%-иар), Ширхэгийн хэмжээ (мм-ээр)						
	1~0.25	0.25~0.05	0.05~0.01	0.01~0.005	0.005~0.001	<0.001	<0.01
0-20	50.7	39.4	1.3	2.1	3.7	2.9	8.6

Шинжилгээний дүнгээр хөрсний урвалын орчин сул шүлтлэг, хөрсний үржил шимийн ерөнхий үзүүлэлтүүдийн хангамж бага, давсжилтгүй, цахилгаан дамжуулах чадваргүй, холбоот элс механик бүрэлдэхүүнтэй цайвар хөрс байна.

ГУРАВ. ТЭСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

3.1. Төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөлөл

Төсөл хэрэгжүүлж буй нутаг дэвсгэрийн байгаль орчин, нийгмийн өнөөгийн төлөв байдал, бохирдол доройтлын түвшин, осол эрсдэлийн үнэлгээг магадлан жагсаах, хяналтын хуудасны аргуудыг ашиглан төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллийг дараах алхмуудаар тодорхойлов.

Алхам нэг. Төслийн зорилго, техник технологийн үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийж эхний ээлжинд анхаарах асуудлуудыг тодорхойлохын тулд нөлөөллийн байж болох эх үүсвэрүүдийг аль болох бүрэн хамруулан нөлөөлөлд өртөж болзошгүй объектуудыг тодорхойлсон.

Хүснэгт 3.1. Сөрөг нөлөөллийн эх үүсвэр (Магадлан жагсаах арга)

№	Төслийн үйл ажиллагаанд байгаль орчны шинжилгээ хийхэд анхаарч нарийвчлан авч үзэх асуудлууд	Хариулт
1	Төсөл хэрэгжүүлэх зориулалтаар усны нөөцийг ашиглах эсэх	Тийм
2	Гадаргын болон газрын доорх усны нөөцийн хомсдол үүсэх эсэх	Үгүй
3	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр болон түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй түүх, соёлын үнэт зүйлс, дурсгалт газар, улсын болон орон нутгийн тусгай хамгаалалтад авсан газар нутаг, байгалийн үзэсгэлэнт газар байгаа эсэх	Тийм
4	Төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчинд сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй ус намгархаг газар, онцгой тогтоцтой уулс, ой мод зэрэг экологийн чухал ач холбогдол бүхий эмзэг газар байгаа эсэх	Тийм
5	Амралт, зугаалгын газар, бусад зориулалтаар олон нийтийн ашигладаг барилга байгууламж, тэдгээрт хүрэх замын маршрут төслийн нөлөөлөлд өртөх эсэх	Үгүй
6	Төсөл хэрэгжүүлэх үе шатанд хатуу, шингэн хог хаягдал үүсэх эсэх	Тийм
7	Гадаргын болон газрын доорх усны чанарт нөлөөлөх эсэх	Үгүй
8	Төслийн хэрэгжих үе шатанд болзошгүй осол, эрсдэл үүсэх эсэх	Үгүй
9	Хөгжлийн хэтийн төлөвлөгөө, орон нутагт хэрэгжиж байгаа буюу хэрэгжүүлэхээр төлөвлөж буй үйл ажиллагаатай холбоотойгоор үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл, бусад хүчин зүйлс байгаа эсэх	Үгүй
10	Байгаль орчны бохирдол, доройтол үүсгэж болзошгүй зам, тээврийн үйл ажиллагаа төсөл хэрэгжих нутаг дэвсгэр, түүний ойр орчимд явагдах эсэх	Тийм

Үр дүн: Нөлөөллийн эх үүсвэрүүд

Ажилчдын унд ахуйн усны хэрэглээнд 135м³, жуулчин 324м³, мод усалгаанд 13.1м³ г.м. Нийтдээ 721.9.2м³ ус ашиглах тооцоотой.

Төслийн үйл ажиллагаанаас жилд ойролцоогоор 23 - 32тн хатуу хаягдал үүсэх тооцоотой.

Хаврын улиралд хээрийн түймэр, шар усны үер, хүчтэй салхи зэрэг байгалийн аюултай үзэгдэл тохиолдох, ажилчдын санамсар болгоомжгүйгээс гал түймэр тавих зэрэг осол, эрсдэл үүсэж болзошгүй.

Алхам хоёр. Анхаарах асуудлуудыг тодорхойлсоны үндсэн дээр тухайн төслийн гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүдийн эрчим, цар хүрээ, хугацаа, шинж чанарыг магадлан жагсаах буюу хяналтын хуудасны аргаар тодорхойлж тоон ба чанарын шинжилгээ хийсэн.

Хүснэгт 3.2. Төслөөс байгаль орчинд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллийн хэлбэр, үргэлжлэх хугацаа, эрчим нь нөлөөллийн төрөлтэй уялдах нь

Байгаль орчны үзүүлэлтүүд	Шууд	Шууд бус	Өөрөө зохицуулагдах	Богино хугацааны	Урт хугацааны	Буцаж нөлөөлөх	Буцалтгүй нөлөөлөх	Хүчтэй	Дунд зэрэг	Бага зэрэг
1. Байгалийн нөөц, ашиглалт, байгаль орчны чанарын өөрчлөлт										
Уур амьсгалын өөрчлөлт		x		x			x			x
Газрын доорхи усны нөөц хомсдох		x		x			x			x
Ургамлын нөмрөгт нөлөөлөх		x		x			x			x
Агаарын чанарт нөлөөлөх		x		x			x			x
Хөрсний бохирдол үүсэх	x			x			x			x
Дуу чимээ, шуугианы нөлөө үүсэх		x		x			x			x
Хатуу, шингэн хог хаягдал үүсэх	x				x		x			x
Байгалийн унаган төрх өөрчлөгдөх		x			x		x			x
2. Эдийн засаг, нийгмийн асуудал										
Нийгэм эдийн засагт эерэгээр нөлөөлөх	+				+	+		+		
Орон нутгийн орлого нэмэгдэх	+				+		+	+		
Ядуурлыг бууруулахад дэмжлэг болох	+				+		+		+	
Нийгмийн хариуцлага, соёлд нөлөөлөх	+				+	+		+		
Ажлын байр нэмэгдэх	+				+		+		+	
Улирлын чанартай эрэлт хэрэгцээ нэмэгдэх	+				+	+				+
Үйлчилгээний салбарын үйл ажиллагаанд нөлөөлөх		+			+	+			+	
3. Бусад нөлөөлөл										
Хүчтэй салхи, түймэр, аюул осол		x			x	x				x
Дүн	8	8		6	10	5	11	3	3	9

(+)-ээрэг нөлөөтэй, (x)-сөрөг нөлөөтэй

Үнэлгээний үр дүн:

Төслийн үйл ажиллагааны явцад хөрсний бохирдол, хатуу, шингэн хог хаягдал үүсэх нь байгаль орчинд шуудаар урт хугацаанд багаас дунд эрчимтэйгээр сөргөөр нөлөөлж байна.

Харин эдийн засаг нийгмийн асуудалд шуудаар урт хугацаанд хүчтэй болон дунд зэргийн эрчимтэйгээр эерэг нөлөө үзүүлэхээр байна. Нийт нөлөөллийн 7 нь буюу 46.6 орчим хувь урт хугацаанд эерэгээр нөлөөлнө. Нөлөөллийн эрчимшлийн хувьд нийт нөлөөллийн 60.0% нь бага, 20.0% нь дунд, 20.0% нь хүчтэй нөлөөлөлтэй байна.

ТӨСЛИЙН ГОЛ БОЛОН БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭ, ЗӨВЛӨМЖ:

Төслийн байршил
<ul style="list-style-type: none"> • Газрыг зориулалтын дагуу ашиглах, газрын хил, заагийг тэлэхгүй байх • Төслийн үйл ажиллагаа нь хүрээлэн буй орчны даац хэвийн байх нөхцөлийг алдагдуулахгүй байх
Агаар орчин
<ul style="list-style-type: none"> • Ажлын байр болон гадна орчны тоосжилтыг бууруулах, чийгшүүлэх, усан оргилууртай болох, эргэлтийн усыг дахин аширладаг байх • Физик бохирдлыг бууруулах (дуу чимээ, үнэр) • Тээврийн хэрэгслийг зөвхөн зогсоолд байрлуулах • Ахуйн хог хаягдлыг салхины зонхилох чиглэлийн доод талд ус үл нэвтрэх дотортой, зориулалтын саванд хуримтлуулах
Хөрс, газрын гадарга, ургамлан бүрхэвч
<ul style="list-style-type: none"> • Төслийн талбайд ил задгай хог хаяхгүй байх, хуримтлал үүсгэхгүйгээр цэвэрлэж зайлуулж байх • Машин техникийн засвар үйлчилгээнээс гарсан шатах тослох маатериал асгарч, хөрсийг бохирдуулсан тохиолдолд тухай бүр хөрсийг хусаж цэвэрлэх • Талбайд олон салаа зам гаргахгүй байх, тогтсон маршрут гарган тэмдэг тэмдэглэгээ байршуулах • Тодорхой хугацааны давтамжтайгаар гадна орчны цэвэрлэгээ хийж хэвших • Газрын тухай хуулийн 58.5-т заасны дагуу 5 жил тутам газрын төлөв байдал чанарын улсын хянан баталгааны дүгнэлт гаргуулж байх • Хашаан дахь сул шороон хөрстэй талбайг “Авто зогсоол. Ангилал ба ерөнхий шаардлага” MNS 5342:2007, “Явган үний зам, талбайн төлөвлөлт. Техникийн шаардлага” MNS 6808:2019, “Байгаль орчин. Эвдэрсэн газрын нөхөн сэргээлт. Нэр томъёо, тодорхойлолт” MNS 5914:2008, “Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах” MNS 6260:2020 стандартуудыг баримтлан тохижуулах, боломжтой бол ногоон байгууламжийн хэмжээг нэмэгдүүлэх • Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх, хөрсний бохирдлыг бууруулах зорилгоор амралтын чөлөөт талбайд мод, цэцэг тарих, арчлах • Нүүрс, үнсний талбайн ойролцоох өнгөн хөрсийг хуулах, бохирдсон хөрсийг цэвэрлэх, саармагжуулах, цементжүүлэх
Хог хаягдал
<ul style="list-style-type: none"> • Хог хаягдлыг ангилан ялгах хогийн сав байршуулах, • Ахуйн шингэн хаягдлын цооногийг ариутгах, үнэрийн бохирдолгүй байлгахад анхаарах, биобэлдмэл ашиглах • Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлд заасан Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг мөрдөн ажиллах бөгөөд хог хаягдлыг дараах байдлаар ангилан ялгана. Үүнд: Дахивар (дахин ашиглах боломжтой хог хаягдал): Төрөл бүрийн цаас, картон, хуванцар сав, төрөл бүрийн шилэн сав, модон эдлэлийн хаягдал, гялгар уут, гэх мэт.

<p>Энгийн хаягдал: Хүнсний болон ариун цэврийн хэрэглэлийн хаягдал, дахин ашиглах хог хаягдлын ангилалд ороогүй бусад хаягдлууд хамаарна.</p> <ul style="list-style-type: none"> • Хог хаягдал цуглуулах, тээвэрлэх эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан хог тээврийн үйлчилгээний гэрээг сунгах • Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх • Хог хаягдлыг ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях дадал зуршлыг хэвшүүлэх • Хог хаягдлын талаарх хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах
<p>Усан орчин</p>
<ul style="list-style-type: none"> • БОНХСайдын 2013 оны А-156 тушаалаар батлагдсан “Ус ашиглалт, хэрэглээг тоолууржуулах журам” -ын дагуу ажиллах • Ус ашиглуулах дүгнэлтийг үндэслэн Усны тухай хуулийн 28.6, 29.1 дэх заалтын дагуу ус ашиглуулах тухай шийдвэрийг гаргуулах • Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгагдсан хуваарийн дагуу усны шинжилгээг итгэмжлэгдсэн лабораторид хуваарийн дагуу шинжлүүлэх • Чанар муутай ус шугам хоолойн элэгдэл, эвдрэл, зэврэлтийг үүсгэж болзошгүй учраас шугам хоолойг элэгдэл, эвдрэл, зэврэлтээс хамгаалж шүүлтүүр тавих • Усны тухай хуулийн 30 дугаар зүйлийн дагуу ус, рашаан ашиглагчдад тавигдах шаардлагыг хэрэгжүүлэн ажиллах • Ус ашиглалтын тайланг 12 дугаар сарын 20-ны дотор багтаан аймгийн БОАЖГ-т хүргүүлэх
<p>Хөдөлмөр хамгаалал</p>
<ul style="list-style-type: none"> • Ажилчдыг хөдөлмөр хамгаалал болон сургалт мэдээллээр тогтмол хангах • Ажилчдыг эрүүл мэндийн үзлэг, шинжилгээнд жил бүр хамруулдаг байх
<p>Галын аюулгүй байдал</p>
<ul style="list-style-type: none"> • Гал түймрээс урьдчилан сэргийлэх талаар ажилтнуудад сургалт зохион байгуулан, сурталчилгаа явуулдаг байх, • Гал унтраах зориулалтын техник хэрэгслийг мэргэжлийн байгууллагын зөвлөмжийн дагуу бэлтгэн, багаж хэрэгслийг байнгын бэлэн байлгах, • Галын аюулаас урьдчилан сэргийлэх талаар анхааруулга, санамж хийж, шаардлагатай газруудад нүдэнд үзэгдэхүйц ил байрлуулах.
<p>Болзошгүй осол, байгалийн гамшиг</p>
<ul style="list-style-type: none"> • Техник, тоног төхөөрөмжийн эвдрэл, гэмтэл, бүрэн бүтэн байдалд байнгын хяналт тавьдаг байх • Ажилтан бүрийг тоног төхөөрөмжтэй харьцаж ажиллах болон аюулгүй ажиллагааг хангах чадварыг бүрэн эзэмшүүлэх • Аянга зайлуулагч, үер усны гамшгаас хамгаалсан хамгаалалт, гал унтраах хэрэгслээр бүрэн тоноглох
<p>Байгаль орчны асуудал хариуцсан нэгж болон ажилтантай байх</p>
<ul style="list-style-type: none"> • БОМТ, Байгаль орчны аудит, Газрын төлөв байдал, чанарын улсын хянан баталгаа, экологийн паспорт зэрэг байгаль орчны хамгаалахад чиглэсэн гол үйл ажиллагааны талаар мэдлэгтэй байгаль орчны асуудал хариуцсан тусдаа ажилтантай болох
<p>Зөвшөөрөл, бичиг баримт</p>
<ul style="list-style-type: none"> • Хог, түүхий эд, бүтээгдэхүүн нийлүүлэх гэрээг холбогдох ААНБ-уудтай байгуулан ажиллах • Ус ашиглах гэрээ, ус ашиглуулах дүгнэлт авах(жил бүр), усны боломжит нөөцийн дүгнэлт (5 жил тутам) • Холбогдох тусгай зөвшөөрлүүдийг хугацаанд нь сунгах

ДӨРӨВ. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТУХАЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний гол зорилго нь төслийн үйл ажиллагаанаас байгаль орчин, хүний эрүүл мэндэд үзүүлж болзошгүй сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээг төлөвлөхөд оршино. Тухайн жилийн БОМТ-д төслийн үйл ажиллагаанаас хөрс, ус, агаарын чанарт хэрхэн нөлөөлж байгааг тодорхойлох үүднээс орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг төлөвлөдөг.

Төслийн 2024 оны БОМТ-г боловсруулахдаа Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны А/618 дугаар тушаалаар батлагдсан “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам”-ын 3 дугаар хавсралтын Дэд бүтцийн төслийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний агуулгын дагуу боловсруулав.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө (6), Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө (2), осол, эрсдэлийн төлөвлөгөө (3), хог хаягдлын менежментийн төлөвлөгөө (3), орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (4), удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө (10), БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах (4), нийт 29 ажил, арга хэмжээ багтсан бөгөөд тэдгээрийг хэрэгжүүлэхэд 48.5 сая.төг зарцуулахаар төлөвлөв.

Хүснэгт 4.1. 2024 оны БОМТ-ний зардлын товчоо

№	Ажлын чиглэл	Хийгдэх ажлын тоо	Төсөв, мян.төг	Үнэлгээ	Эзлэх хувь
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	6	14 490.0	Маш их	43
2	Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө	2	22 000.0		
3	Осол, эрсдэлийн төлөвлөгөө	3	200.0	Их	31
4	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	3	1 450.0		
5	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	4	150.0	Дунд	14
6	Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	10	10 300.0	Бага	12
7	БОМТ-ний хэрэгжилтийг олон нийтэд тайлагнах	3	-		
Нийт төсөв (мян.төг)		29	48 590.0		100

Зөвлөмж:

Хууль, журмын дагуу төсөл хэрэгжүүлэгч тухайн жилийн БОМТ-нд тусгасан ажлыг 90 хувиас дээш биелэлттэй хийсэн тохиолдолд дараа оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөг XII сарын 31-ний дотор аймгийн БОАЖГ-аар батлуулахыг анхаарах.

БОМТ-ний дагуу хийсэн ажлуудыг тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн тайланд дэлгэрэнгүй тусгаж өгөх тул тухайн хийж гүйцэтгэсэн ажил тус бүрт нотлох баримтуудыг бүрдүүлсэн байх нь чухал.

Тухайн жилийн БОМТ-ний хэрэгжилтийн тайланг хянаж, батлахад БОМТ-нд тусгагдсан ажлуудыг ач холбогдлоор нь үнэлдэг тул төлөвлөгөөнд туссан арга хэмжээний эзлэх хувийг анхаарч ажиллах нь зүйтэй.

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛӨӨС СЭРГИЙЛЭХ, БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 5.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн Зардал, мян.төг	Тоо хэмжээ	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг	
1	2	3	4	5	6	7	8	9	
Хөрс элэгдэж, эвдрэх, бохирдох	Хогийн цэгт 2 төрлийн ангилан ялгах сав шинээр байршуулна	Төслийн талбайд	ш	120.0	2	240.0	Төслийн хугацаанд	Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3, Хог хаягдлын тухай тухай хуулийн 9.2.2, 9.4.8	
	Хашаа хашлага хийх		га	14000.0	1.6	14000.0			
	Эко-00 барьж, усанд орох газрыг шинээр барина		Хийгдсэний дараа гарсан зардлаар тооцно						
	Майхан толгой ойд нөхөн сэргээлт хийх								
Усны нөөц хомсдох	Худагт усны зарцуулалт, ашиглалтыг хянах тоолуур суурилуулах	ш	250.0	-	250.0			БОНХС-ын 2013 оны А-156 тоот тушаал “Ус ашиглалт хэрэглээг тоолуур-жуулах журам”	
Агаар орчин бохирдох	Агаар бохирдуулах эх үүсвэр ашиглахгүй байх, хийн болон цахилгаан зуух ашиглах	ш	-	-	-			Эрүүл ахуйн тухай хуулийн 4.4.3	
Нийт зардал							14 490.0	-	-

ЗУРГАА. ОРЧНЫ ТОХИЖИЛТ, ЦЭЦЭРЛЭГЖҮҮЛЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 6.1. Орчны тохижилт цэцэрлэгжүүлэлтийн төлөвлөгөө

Орчны тохижилт, цэцэрлэгжүүлэлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хэмжих нэгж	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян.төг	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8	9
Хөрсөн бүрхэвчийг хамгаалж ногоон байгууламж бий болгох	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд тарьсан мод, бугыг арчлах	Эзэмшил газрын хашаанд	ш	10 бут, 50 ш тарьц	-	2000.0	Төсөл хэрэгжих хугацаанд	Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 6.5.4, Зүлэгжүүлэх талбай бэлтгэх, үр тарих, арчлах стандарт MNS6260:2011
Тохижилтын ажлын хүрээнд гадаад дотоодын аялагч, жуулчдын тав тухыг хангах	Модон жижиг байшин барих		ш	2	10000.0	20000.0		
Нийт зардал						22000.0	-	-

ДОЛОО. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 7.1. Осол эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хэмжээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, мян. төг	Нийт зардал төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Гал, түймрийн аюул, осол	Галаас хамгаалах тэмдэг тэмдэглэгээг шинэчлэн сайжруулах	Ажилчдын байранд	1 ш	50.0	50.0		
	Гал унтраах хэрэгсэл сэлбэх	Төслийн талбайд	1 ком	150.0	150.0	Төсөл хэрэгжих хуацаанд	Хөдөл-мөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль
	Ажиллагсдад ХАБ-ын болон галын аюулгүй байдлын сургалт явуулах	Ажилчид	10 хүн	-	-		
Нийт							200.0

НАЙМ. ХОГ ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 8.1 Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө

Хог хаягдлын ангилал	Серег нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ	Серег нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төг	Нийт Зардал, мян.төг	Хэрэгжих хугацаа, давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
1	2	3	4	5	6	7	8
Ахуйн	Хог тээврийн гэрээнд заасан хугацаанд хог хаягдлыг зайлуулах	Төслийн талбайд	м ³	-	300.0	Дулааны улиралд	“Хог хаягдлын тухай” хууль”-ийн 10.2.3-р зүйл
	Шингэн хаягдлыг зайлуулах		машин	-	1000.0		
	Бохирын цооногт 1м ³ бохирт 1 л био бэлдмэл байхаар тооцож тогтмол ариутгал хийх		л	-	150.0		
Үйлдвэрлэлийн	-	-	-	-	-	-	-
Аюултай	-	-	-	-	-	-	-
Нийт зардал					1450.0	-	-

ЕС. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Хүснэгт 9.1 Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

Хяналт шинжилгээний үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Давтамжийн тоо	Нэгжийн зардал	Нийт зардал, мян.төг	Тайлбар	Баримтлах стандарт
1	2	3	4	5	6	7	8
Хөрсний бохирдол	<ul style="list-style-type: none"> Хогийн цэг, Автомашини зогсоолоос 			50.0	50.0	Хром, Сг / 150мг/кг	Баримтлах стандарт: “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2008
						Хар тугалга, Рb / 100мг/кг	
						Кадмий, Cd / 3мг/кг	
						Никель, Ni / 150мг/кг	
						Цайр, Zn / 300мг/кг	
						Зэс, Cu / 100мг/кг	
						Төмөр, Fe	
						pH	-
Хөрсний агрохимийн найрлага	Талбайн төв хэсгээс			50.0	50.0	Ялзмаг, %	-
						Давс, %	-
Хөрсний механик бүрэлдэхүүн			1	50.0	50.0	ЦДЧ, dS/m	-
						NO ₃ , мг/л	-
						Элс	-
						Тоос	-
						Шавар	-
						pH / 6.5-8.5	
						Ерөнхий хатуулаг / 7.0мг-экв/л	
Усны чанар	Хүдгийн уснаас жилд 1 удаа			50.0	50.0	Хлорид ион / 350.0мг/л	“Ундны ус. Эрүүл ахуйн шаардлага, чанар, аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2005
						Сульфатын ион / 500.0мг/л	
						Кальцийн ион / 100.0мг/л	
						Магнийн ион / 30.0мг/л	
						Натри ион / 200.0мг/л	
						Хуурай үлдэгдэл / 1000.0мг/л	
Нийт зардал					150.0		

АРАВ. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт 10.1 Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

Төлөвлөсөн арга хэмжээ	Урьдчилан тооцсон төсөв, мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь 2024 он				Хариуцсан албан тушаалтан	Тайлбар
		IV-V	VI-VII	X-XI			
		3	4	5	6		
1	2						
БОМТ-г олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх ажлыг хуваарийн дагуу зохион байгуулах	300.0				Менежер	-	
Ажилчдыг хөдөлмөр хамгааллын хэрэгслээр хангах, эмийн сан, гал унтраах хэрэгсэл бэлэн байлгах	Осол, эрсдэлтйн менежментийн төлөвлөгөөнд туссан зардлаар				Менежер	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”	
Байгалийн гамшиг болон гэнэтийн осол, аваараас урьдчилан сэргийлэх,	Орчны тохижилтын төлөвлөгөөнд туссан зардлаар				Менежер	“Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль”	
Тэрбум мод үндэсний хөтөлбөрийн хүрээнд зохион байгуулагдах ажилд идэвх санаачлагатай оролцох	Орчны тохижилтын төлөвлөгөөнд туссан зардлаар				Менежер	Тэрбум мод үндэсний хөтөлбөр	
Нийгмийн хариуцлагын хүрээнд сум, багаас зохион байгуулах арга хэмжээнд идэвхтэй оролцох	Гэрээнд зааснаар				Менежер	Нийслэл, дүүргийн Засаг даргын захирамж	
Ус ашиглуулах зөвшөөрөл авч, гэрээ байгуулах	Ус ашиглалтын хэмжээгээр				Менежер	Усны тухай хууль	
Усны нөөц ашигласны төлбөрийг ашиглалтын хэмжээнээс хамаарч жил бүр төлөх	Үйл ажиллагааны зардлаар				Менежер	Усны тухай, Төсвийн тухай хууль	
Ус ашиглалтын тайланг 12 дугаар сарын 20-ны дотор багтаан аймгийн БОГ-т хүргүүлэх	-				Менежер	“Улсын усны мэдээллийн сан бүрдүүлэх үзүүлэлт, хөтлөх журам”	
Холбогдох гэрээүүдийг хугацаанд нь сунгаж байх	10 000.0				Менежер	“Хог хаягдлын тухай хууль”	
Задгай талбайг шинэчлэн засварлах ажил хийх, баазын цахилгааны монтажийг мэргэжлийн байгууллагын тусламжтайгаар шинэчлэх	10 300.0				Менежер	-	
Нийт							

АРВАН НЭГ. ТУХАЙН ЖИЛИЙН БОМТ-НИЙ ХЭРЭГЖИЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСЭД ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

БОМТ-г боловсруулах болон тайлагнах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасны дагуу тэднийг үнэн зөв, бодит мэдээллээр хангах, нутгийн захиргааны байгууллагын саналыг тусгах зорилготой юм.

Хүснэгт 11.1. БОМТ-ний биелэлтийг олон нийтэд тайлагнах, хэлэлцүүлэх хуваарь

БОМТ-г хэлэлцүүлэх оролцогч талууд	Тайлагнах хэлэлцүүлэх хэлбэр	Арга хэмжээ	Хугацаа	Хариуцан зохион байгуулах ажилтан	Зохион байгуулах газар
Холбогдох албан тушаалтан	Хэрэгжүүлсэн ажлаа тайлагнах, хэлэлцүүлэх, санал авах	Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тухай	Жил бүрийн X сард	Менежер	Төсөл хэрэгжиж буй багийн Иргэний танхимд
Орон нутгийн иргэд, багийн ИНХ					
Шаардлагатай тохиолдолд сонирхогч талууд, байгаль орчны төрийн бус байгууллага	Төслийн үйл ажиллагаа болон байгаль орчныг хамгаалах, сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн X сард	Компанийн байранд		
Аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газар	Ажлын тайланг хянуулж, төлөвлөгөөг батлуулах	Төслийн үйл ажиллагаанаас хүрээлэн буй орчин, ажлын байранд үзүүлж буй сөрөг нөлөөллийг бууруулах, хяналт шинжилгээний чиглэлээр хийгдэж буй ажил	Жил бүрийн XII сарын 31-ний дотор	Аймгийн БОГ, БОАЖЯ	

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. БОАЖСайдын 2019 оны А/618 тоот тушаал, “Байгаль орчны менежментийн төлөвлөгөө боловсруулах, хянан батлах, тайлагнах журам
2. Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2017.12.12-ны өдрийн А/349-р тушаал “Эх үүсвэрээс гарах хог хаягдлын кодчилсон жагсаалт, тэдгээрийн зэрэглэл”
3. Байгаль орчны хуулийн эмхэтгэл, УБ хот, 2012 он
4. БОАЖЯ, “Усны тухай хууль тогтоомжийн эмхэтгэл”, 2020 он
5. “Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага” MNS 4585:2016 стандарт
6. “Ундны усны стандарт. Эрүүл ахуйн шаардлага, чанар аюулгүй байдлын үнэлгээ” MNS 0900:2018 стандарт
7. “Хөрсний чанар. Хөрс бохирдуулагч бодис, элементүүдийн зөвшөөрөгдөх дээд хэмжээ” MNS 5850:2019 стандарт
8. Бусад холбоо бүхий мэдээ материал



Байгаль орчны зөвлөх үйлчилгээний “Цагаан уулын оргил” ХХК

Хаяг: Сүхбаатар дүүрэг 1-р хороо, Чингисийн Өргөн Чөлөө,
“Бизнес плаза” 501 тоот

Утас: 99184930

Цахим майл хаяг: tsagaanuuiliinorgil@gmail.com